



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/464

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн №109 дүгээр тогтоол, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/434 дүгээр захирамжийн хавсралтын 2 дугаар хэсэгт Мөрөн сумын Засаг даргын тамгын газар (РД:9070192)-т эзэмшүүлсэн Мөрөн сумын 1 дүгээр баг Стадионы ар талд байршилтай 6712017706 нэгж талбарын дугаар бүхий төрийн захиргааны байгууллагын зориулалттай 46422м² газрыг Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар (РД:9070354)-т шилжүүлэн үлдсэн 29 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/434 дүгээр захирамжийн хавсралтын 2 дугаар хэсгийг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар эзэмшигч Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар (РД:9070354)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ